Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 107,455.0 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
А	1	2	3=2-1	4
Бараа материал	354,073.0	450,695.1	96,622.1	27.3
Үндсэн хөрөнгө	3,047,356.2	2,843,279.1	(204,077.1)	(6.7)
Нийт хөрөнгийн дүн	3,401,429.2	3,293,974.2	(107,455.0)	(3.2)
Өмч: - төрийн	1,233,841.0	1,233,841.0	-	-
Хуримтлагдсан үр дүн	1,746,307.7	1,638,852.7	(107,455.0)	(6.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	421,280.5	421,280.5	-	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,401,429.2	3,293,974.2	(107,455.0)	(3.2)

Бараа материалын дансны үлдэгдэл 450,695.1 мянган төгрөг болж, 96,622.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 277,159.0 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан 120,987.1 мянган төгрөг, бусад 5,037.0 мянган төгрөг, нийт 403,183.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд үйл ажиллагаанд зарцуулсан 296,074.1 мянган төгрөг, акталсан 10,486.9 мянган төгрөг, нийт 306,561.0 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хассантай холбоотой байна. Бараа материалын дансны 85.9 хувийг 244,411.1 мянган төгрөгийн тусгай зориулалттай материал, 142,839.2 мянган төгрөгийн аж ахуйн материал бүрдүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,843,279.1 мянган төгрөг болж, 204,077.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 847.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны 200 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 4,700.9 мянган төгрөг, нийт 5,547.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн 209,625.0 мянган төгрөгийн зардлаар буурсан байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 107,455.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүн алдагдлыг мөн дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Тус лабораторийн биет бус хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн 4,000.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий байгууллагын цахим хуудас, 1,800.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий Dupatic санхүүгийн онлайн программыг үйл ажиллагаанд ашиглаж байна. Үүнээс Dupatic санхүүгийн программын хувьд үйлчилгээний төлбөр 640.0 мянган төгрөг, цахим хуудасны үйлчилгээний төлбөр 600.0 мянган төгрөг тус тус төлжээ.

Хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй Дата ланд технологи ХХК-ийн “Төсвийн нэгдсэн систем” программын үйлчилгээний төлбөр 5,760.0 мянган төгрөгийг төлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус лабораторийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,033,032.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 210,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,243,032.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөрөнгийн зардлыг 372,158.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 160,206.8 мянган төгрөгөөр, цалин хөлс, шимтгэлийн зардлыг 94,850.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 73,137.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 51,516.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 44,574.4 мянган төгрөгөөр, бусад зардлыг 71,816.6 мянган төгрөгөөр буюу нийт зардлыг 868,261.4 мянган төгрөгөөр бууруулж, 1,374,771.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2025 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй хөрөнгийн зардлыг дээд газраас хүлээн зөвшөөрөөгүй зэргээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 157,004.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,321,776.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 210,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,228,481.7 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогоос 222,159.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,450,641.5 мянган төгрөг буюу 94.7 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 19,458.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,366.2 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 10,700.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 23,338.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 10,323.8 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 1,080.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

Д.д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт				
	70805 Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	1,531,776.1	1,450,641.5	81,134.6	94.7
1	70805 Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	1,477,046.0	1,395,911.5	81,134.5	94.5
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,401,925.8	1,331,312.7	70,613.1	95.0
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	35,679.7	34,598.8	1,080.9	97.0
1.3	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх	39,440.5	30,000.0	9,440.5	76.1
2	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	54,730.1	54,729.9	0.2	100.0
2.1	82504 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	46,497.0	46,496.9	0.1	100.0
2.2	82548 Мал амьтан эрүүлжүүлэх	8,233.1	8,233.1	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус газрын захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар лабораторийг 29 орон тоотой байхаар баталсан ба тайлант онд орон тооны цомхотгол хийгээгүй, 29 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна. Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолоор Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори УТҮГ-т нэгтгэхээр болсон.

Тус лаборатори нь Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.5 дахь заалтаар хоолны хөнгөлөлтийг 1-ээс 3 дугаар сард нэг өдрийн 15.0 мянган төгрөгөөр тооцон олгож байсан бол захирлын 2025 оны А/26 дугаар тушаалаар 4 сараас эхлэн нэг өдрийн 25.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 төгрөг болгон нэмэгдүүлж, нийт 154,802.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгожээ.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ОБЕГ болон МЭЕГ-ын хамтарсан команд штабын сургалт явуулахад зориулж, МЭЕГ-аас 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг галын хор, халдвар хамгааллын иж бүрэн хувцас, болон бусад холбогдох материалуудыг худалдан авч зориулалтын дагуу зарцуулсан болно.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 109,000.0 мянган төгрөгийн дүн бүхий 10 төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаж баталсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно” гэсэн заалтыг үндэслэж шууд худалдан авах аргыг ашиглан 102,937.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 3. Худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

№	Худалдан авах бараа, ажил үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	Хэтрэлт (-), хэмнэлт (+)	Худалдан авалтын арга
1	Омог сэргээхэд	3,500.0	3,500.0	-	ШХА
2	Химийн стандарт бодис худалдан авах	11,500.0	15,581.4	(4,081.4)	ШХА
3	Туршилтын мал амьтан авах	20,000.0	25,200.0	(5,200.0)	ШХА
4	Ариутгалын бодис	9,158.0	9,158.0	-	ШХА
5	Мал амьтаны өвс, тэжээл, байцаа, лууван	10,500.0	7,772.0	2,728.0	ШХА
6	Туршилтын жижиг амьтан худалдан авах	5,000.0	4,932.0	68.0	ШХА
7	Тэжээлт орчин худалдан авах	5,242.0	6,014.0	(772.0)	ШХА
8	Хорголжин тэжээл	19,800.0	19,500.0	300.0	ШХА
9	Туршилтын гахай	19,800.0	1,500.0	18,300.0	ШХА
10	Лабораторийн цэвэрлэгээний материал	4,500.0	9,780.0	(5,280.0)	ШХА
	Дүн	109,000.0	102,937.4	6,062.6	

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн лабораторийн үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийг хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Гроут финанс аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Нарантуяа, аудитор Б.Нансалмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Ч.Хүнбиш, гүйцэтгэх захирал Б.Бямбадорж нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 26/08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосон сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,681,654.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,816.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Тайлант оны төсөвт материаллаг өөрчлөлт ороогүй.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэх, зардал хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудыг хэмнэж 81,134.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож үүнээс 93,294.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу орсон, төсөвлөсөн өөрийн үйл ажиллагааны орлогыг 112,159.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 169 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бидний гүйцэтгэсэн аудитын горим, сорилоор бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцээгүй асуудал илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлс нь холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, холбогдох данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж 3,333.1 мянган төгрөгийн 3 алдаа илрүүлснийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулж, аудитын явцад бүрэн залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 32,021.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 80.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	5	32,021.8	4	27,761.8	80.0
Нийт дүн	5	32,021.8	4	27,761.8	80.0

Ахмадын сан байгуулан ажиллаагүй ирсэн шалтгаан нь цалингийн сангийн хүрэлцээ муутайгаас гэсэн тайлбар ирүүлсэн ба Засгийн газрын 2025 оны 153 дугаар тогтоолоор тус байгууллагыг "Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори" УТҮГ-т нэгтгэх болсон тул дараагийн шатны арга хэмжээ төлөвлөөгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журмын дагуу бэлтгээд Finperform программ руу оруулахад санхүүгийн программаас хөрвүүлэлт хийгдэхгүй, гараар шивэлт үүсгэж оруулж байна. Мөн хоорондын тооцоо, төвлөрүүлсэн шилжүүлэгийн устгал хийгдэх процесс удаашралтай зэрэг хүндрэлүүд гарч байгааг сайжруулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,313.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Төсвийн тохируулгыг үнэн зөв хийгээгүйгээс "Төсвийн гүйцэтгэлийн тайлан"-д "Улсын төсвөөс санхүүжих" орлогын дүнг төвлөрүүлэх шилжүүлэг 3,512.0 мянган төгрөгөөр тохируулан тайлагнаагүй, мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагыг 847.0 мянган төгрөгөөр дутуу, үйл ажиллагааны мөнгөн зарлагыг мөн дүнгээр илүү тайлагнасан нь УСНББОС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал 27, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй;
- Цалингийн зардлыг 954.4 мянган төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг мөн дүнгээр илүү тайлагнасан нь УСНББОС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал 27, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Аудитаар нийт 7,546.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 3,474.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 4,072.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,546.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,270.1 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Албан томилолтоор ажилласан хугацаанд цалин дээр давхардуулан хоол, унааны хөнгөлөлт 639.0 мянган төгрөгийг нэр бүхий 8 ажилтанд олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 639.0 мянган төгрөгийн хоол унааны хөнгөлөлтийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх.

5.2 Албан шаардлага

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн[На1.1] аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан үндэслэлээр нягтлан бодогчид 1,559,000.00 /Нэг сая таван зуун тавин есөн мянган/ төгрөг, няравт 1,276,000.00 /Нэг сая хоёр зуун далан зургаан мянган/ төгрөг, нийт 2,835,000.00 /Хоёр сая найман зуун гучин таван мянган/ төгрөгийн балансын урамшууллыг ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна" 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: Цалингийн мэдээ, мэдээллийг алдаатай оруулснаас 4,072.4 мянган төгрөгийн цалинг нэр бүхий 9 ажилтанд зөрүүтэй тооцон олгосон. Үүнээс илүү цагийн нэмэгдэл 1,450.6 мянган төгрөг, шөнө ажилласны нэмэгдэл 2,266.2 мянган төгрөг, ур чадварын нэмэгдэл 297.6 мянган төгрөг, улирлын ажлын мөнгөн урамшуулал 58.0 мянган төгрөг тус тус байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж хэвших, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
								Залруулсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн тохируулгыг буруу хийсэн	1	4,359.0			1	4,359.0	1	4,359.0
2	Зардлын ангилал буруу	1	954.4			1	954.4	1	954.4
Нийт дүн		2	5,313.3	-	-	2	5,313.3	2	5,313.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тус газрын захирлын 2025 оны дугаар сарын 13-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар "2024 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нь нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөг , няравт 1,276.0 мянган төгрөг, нийт 2,835.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.	1	2,835.0			1	2,835.0		
2	Албан томилолтоор ажилласан хугацаанд цалин дээр давхардуулан хоол, унааны хөнгөлөлт 639.0 мянган төгрөгийг нэр бүхий 8 ажилтанд олгосон.	1	639.0	1	639.0				
3	4,072.4 мянган төгрөгийн цалинг нэр бүхий 9 ажилтанд зөрүүтэй тооцон олгосон. Үүнээс илүү цагийн нэмэгдэл 1,450.6 мянган төгрөг, шөнө ажилласны нэмэгдэл 2,266.2 мянган төгрөг, ур чадварын нэмэгдэл 297.6 мянган төгрөг, улирлын ажлын мөнгөн урамшуулал 58.0 мянган төгрөг тус тус байлаа.	1	4,072.4					1	4,072.4
Дүн		3	7,546.4	1	639.0	1	2,835.0	1	4,072.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 98/A0150079

Улаанбаатар хот

САГ-2026/105/НА -СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор ажилласан хугацаанд цалин дээр давхардуулан хоол, унааны хөнгөлөлт 639,000.00 /Зургаан зуун гучин есөн мянган/ төгрөгийг нэр бүхий 8 ажилтанд олгосон.

Энэ "Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулалтгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан томилолтоор ажилласан хугацаанд цалин дээр давхардуулан хоол, унааны хөнгөлөлт 639,000.00 /Зургаан зуун гучин есөн мянган/ төгрөгийг тооцоо бодсон нягтлан бодогч У.Баатаржав, хянасан, шийдвэр гаргасан захирал С.Тэсхуяг нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн захирал /С.Тэсхуяг/, нягтлан бодогч /У.Баатаржав/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Б.БЯМБАДОРЖ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 493/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/105/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан үндэслэлээр нягтлан бодогчид 1,559,000.00 /Нэг сая таван зуун тавин есөн мянган/ төгрөг, няравт 1,276,000.00 /Нэг сая хоёр зуун далан зургаан мянган/ төгрөг, нийт 2,835,000.00 /Хоёр сая найман зуун гучин таван мянган/ төгрөгийн балансын урамшууллыг ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11.хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал."-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын захирал /С.Тэсхуяг/, нягтлан бодогч /У.Баатаржав/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Б.БЯМБАДОРЖ

